

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjenmagadlahui ezshaudit,mn Улаанбаатар хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjenmagadlahui.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Б.ОРГИЛ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.28 № 57

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2023 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 86.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 3.6 хувийг хангамж бараа материалын зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг, 241 дүгээр тогтоолоор албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталж, 2023 оны 07 дугаар 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын алба нь байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 90.9 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. 098030073

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>363,280.00</u>	<u>1,783,680.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	363,280.00	1,783,680.00
354	Хангамжийн материал	363,280.00	1,783,680.00
35470	Бусад хангамжийн материал	363,280.00	1,783,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,735,371,859.15</u>	<u>3,666,087,392.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,735,371,859.15	3,666,087,392.81
392	Биет хөрөнгө	82,059,859.15	12,775,392.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,416,300.00	30,916,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,674,075.34)	(20,515,925.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,267,270.00	9,267,270.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,949,635.51)	(6,892,252.10)
393	Биет бус хөрөнгө	3,653,312,000.00	3,653,312,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,653,312,000.00	3,653,312,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,735,735,139.15</u>	<u>3,667,871,072.81</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,735,735,139.15</u>	<u>3,667,871,072.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,735,735,139.15	3,667,871,072.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,673,272,955.00	3,673,272,955.00
512	Хуримтлагдсан үр дүн	62,118,041.15	(5,746,025.19)
51210	Өмнөх үеийн үр дүн	62,118,041.15	62,118,041.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(67,864,066.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	344,143.00	344,143.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,735,735,139.15</u>	<u>3,667,871,072.81</u>

СТ-2А

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	513,942,601.00	847,595,592.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,942,601.00	847,595,592.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,557,001.00	614,496,492.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	357,557,001.00	614,496,492.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,385,600.00	233,099,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,385,600.00	233,099,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,551,054.36	848,709,658.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,551,054.36	848,709,658.34

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532,856,168.03	823,508,472.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,875,723.00	179,154,167.00
210101	Үндсэн цалин	77,100,452.00	97,029,655.00
210102	Нэмэгдэл	26,583,703.00	56,248,591.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,787,500.00	6,680,000.00
210104	Урамшуулал	7,404,068.00	19,195,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,711,194.00	21,683,689.91
210201	Тэтгэврийн даатгал	9,752,492.44	15,018,158.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,147,351.51	1,791,541.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	917,881.19	1,433,233.33
210204	Ажилгүйдлийн даатгал	172,133.33	312,794.19
210205	Эрүүл мэндийн даатгал	1,721,335.53	3,127,961.79
2104	Хангамж, бараа материалын зардал	8,198,414.67	8,208,820.18
210401	Бичиг хэрэг	1,104,050.00	1,237,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,070,000.00	5,030,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,099,864.67	1,074,520.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	924,500.00	867,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	480,000.00	-
210604	Урсгал засвар	480,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	276,000.00	536,000.00
210702	Дотоод албан томилолт	276,000.00	536,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,156,383.00	608,391,329.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	359,029,747.00	595,519,393.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	166,700.00	902,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,010,000.00
210807	Газрын төлбөр	10,959,936.00	10,959,936.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,158,453.36	5,534,466.34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,158,453.36	5,534,466.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	694,886.33	25,201,185.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,417,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,417,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	694,886.33	20,783,685.91
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	694,886.33	20,783,685.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,608,453.36)	(1,114,066.34)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	66,750,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	66,750,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(66,750,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,608,453.36)	(67,864,066.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>513,942,601.00</u>	<u>847,595,592.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,942,601.00	847,595,592.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,557,001.00	614,496,492.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	357,557,001.00	614,496,492.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,385,600.00	233,099,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,385,600.00	233,099,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>508,392,601.00</u>	<u>844,595,592.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	508,392,601.00	844,595,592.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,697,714.67	819,394,406.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,875,723.00	178,944,222.00
210101	Үндсэн цалин	78,736,633.00	96,842,674.00
210102	Нэмэгдэл	25,067,522.00	56,045,782.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,667,500.00	6,859,845.00
210104	Урамшуулал	7,404,068.00	19,195,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,711,194.00	21,893,634.91
210201	Тэтгэврийн даатгал	9,752,493.48	15,228,103.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,147,351.51	1,791,541.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	917,881.19	1,433,233.33
210204	Ажилгүйдлийн даатгал	172,133.33	312,796.44
210205	Эрүүл мэндийн даатгал	1,721,334.49	3,127,959.54
2104	Хангамж, бараа материалын зардал	8,198,414.67	8,389,220.18
210401	Бичиг хэрэг	1,104,050.00	1,237,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,070,000.00	5,030,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,099,864.67	1,074,520.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	924,500.00	1,047,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	480,000.00	-
210604	Урсгал засвар	480,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	276,000.00	536,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	276,000.00	536,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,156,383.00	609,631,329.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	359,029,747.00	596,759,393.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	166,700.00	902,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,010,000.00
210807	Газрын төлбөр	10,959,936.00	10,959,936.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	694,886.33	25,201,185.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,417,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,417,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	694,886.33	20,783,685.91
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	694,886.33	20,783,685.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,550,000.00</u>	<u>3,000,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,550,000.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,550,000.00	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,550,000.00	3,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,550,000.00	3,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,550,000.00)</u>	<u>(3,000,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(67,864,066.34)	(67,864,066.34)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	(5,746,025.19)	3,667,871,072.81

ТГ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,882,400.00	232,097,713.09	(23,784,686.91)	90.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,882,400.00	232,097,713.09	(23,784,686.91)	90.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,464,900.00	227,680,213.09	(23,784,686.91)	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,338,200.00	178,944,222.00	(20,393,978.00)	89.8
210101	Үндсэн цалин	95,275,000.00	96,842,674.00	1,567,674.00	101.6
210102	Нэмэгдэл	82,890,000.00	56,045,782.00	(26,844,218.00)	67.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,470,000.00	6,859,845.00	(1,610,155.00)	81.0
210104	Урамшуулал	12,703,200.00	19,195,921.00	6,492,721.00	151.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,917,400.00	21,893,634.91	(3,023,765.09)	87.9

210201	Тэтгэврийн даатгал	16,943,800.00	15,228,103.93	(1,715,696.07)	89.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,993,400.00	1,791,541.67	(201,858.33)	89.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,594,700.00	1,433,233.33	(161,466.67)	89.9
210204	Ажилгүйдлийн даатгал	398,700.00	312,796.44	(85,903.56)	78.5
210205	Эрүүл мэндийн даатгал	3,986,800.00	3,127,959.54	(858,840.46)	78.5
2104	Хангамж, бараа материалын зардал	8,655,900.00	8,389,220.18	(266,679.82)	96.9
210401	Бичиг хэрэг	1,211,000.00	1,237,100.00	26,100.00	102.2
210402	Тээвэр, шатахуун	5,229,900.00	5,030,000.00	(199,900.00)	96.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,315,000.00	1,074,520.18	(240,479.82)	81.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,000.00	1,047,600.00	147,600.00	116.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	536,000.00	536,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	536,000.00	536,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,017,400.00	14,917,136.00	(100,264.00)	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,105,400.00	2,045,200.00	(60,200.00)	97.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	902,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,010,000.00	1,010,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	11,000,000.00	10,959,936.00	(40,064.00)	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,417,500.00	4,417,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,417,500.00	4,417,500.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,417,500.00	3,417,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,882,400.00	232,097,713.09	(23,784,686.91)	90.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	255,882,400.00	232,097,713.09	(23,784,686.91)	90.7
132001	Орон нутгийн төсвөөс	255,882,400.00	232,097,713.09	(23,784,686.91)	90.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7.00	7.00	-	100.0

620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	
620004	Гэрээт ажилтан			-	

НТГ-2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	609.496.492.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	609.496.492.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	609.496.492.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	609.496.492.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	609.496.492.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	609.496.492.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	609.496.492.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,644.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,644.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.5 дах "санхүүгийн тайлангийн тодруулга" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

2. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Боловсрол, шинжлэх ухааны яамны 2023.07.24-ний 2/3151 дугаар албан бичгийг үндэслэн /балансын урамшуулал/ нэг удаагийн шагнал, урамшууллын 1,614.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, 5,030.0 мянган төгрөгийг бензин талонаор бүртгэсэн нь Санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хэмжилт" батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: "14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.3.бүх өр төлбөр; 14.4.4.аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр; 14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал; 14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материал дансанд бензин талонаар биш шатахууны нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Зардал хооронд гүйлгэн зарцуулсан	1	1,614.0	-	-	-	-	1	1,614.0	-	-	-	-
шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгээгүй	1	5,030.0	-	-	-	-	1	5,030.0	-	-	-	-
Дүн	3	6,644.0	-	-	-	-	3	6,644.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

² Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1	53,944.9					1	53,944.9
Дүн	1	53,944.9					1	53,944.9